

БАТЛАВ:  
“ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ж.МОНХМАРАН

БАТЛАВ:  
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Н.УДААНЖАРГАЛ

## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны 08 сарын 30-ны

Г/603 № ТТЗ-М122/06

Улаанбаатар хот

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү “Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ” -г /цаашид “Гэрээ” гэх/ Нэг талаас Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, 48/1, Капитал хаус, З давхарт байрлах “ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ” ХХК, -ийг төлөөлж Борлуулалт, маркетинг эмчилж замаар захирал Ч.Галмөнх (цаашид “Худалдагч” гэх), Нөгөө талаас Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргэг, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62 Юнион Бюлдинг, Б блок, 11 дэвхэр “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК -ийг төлөөлж Төсөл хөгжлийн газрын дарга Э.Эрдэнэбат (цаашид “Худалдан авагч” гэх) нар Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг үндэслэж энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Гэрээгээ худалдагчаас худалдан авагчид чанар стандартын шаардлагыг хангасан газрын тосны бүтээгдэхүүн, бүх төрлийн шатахуун /цаашид шатахуун гэх/, тос, тосолгооны материал, аккумулятор /цаашид бүтээгдэхүүн гэх/-ийг нийлүүлэх, худалдан авагчаас үнийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

### ХОЁР. БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НИЙЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- 1.1 Худалдагч нь Худалдан авагчид дараах байрлалаар шатахуун болон бүтээгдэхүүнийг нийлүүлнэ. Үндэслэл:
  - 2.1.1 Худалдагч нь Худалдан авагчийн заасан хаяг буюу “Рашаант-Мааньт” чиглэлийн төмөр замын төсөл хэрэгжиж буй Улаанбаатар төмөр замын Мааньт өртөөнд байрлах Шунхлай трейдинг ХХК-ийн зөөврийн Шатахуун түгээх станц, Улаанбаатар төмөр замын Рашаант өртөөнд байрлах Шунхлай Трейдинг ХХК-ийн зөөврийн ШТС;
  - 2.1.2 “Шунхлай Трейдинг” ХХК-ийн ШТС;
  - 2.1.3 Худалдан авагч талын хэрэгцээ шаардлагыг үндэслэж харилцан тохиролцсоноор нэмэлт зөөврийн ШТС-ыг Худалдагч тал байршуулна.
- 2.2 Худалдан авагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан нөхцөлөөр шатахуун болон бүтээгдэхүүнийг худалдан авагч талаас албан ёсны тамга, тэмдэг бүхий зөвшөөрлийн бичгийг үндэслэн авсанаар худалдагч шатахуун болон бүтээгдэхүүнийг нийлүүлсэнд, худалдан авагч нь хүлээн авсанд тус тус гоцло.
- 2.3 Худалдан авагч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй ба төржин, заасан хугацаанд тасралтгүй барааг бэлтгэн нийлүүлнэ.

### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### Худалдагч талын эрх, үүрэг

- 3.1. Монгол Улсын холбогдох чанар, стандартын шаардлага хангасан, эрхийн болон биет байдлын догондолгүй, Худалдан авагчийн захиалгад заасан нэр төрөл, үнэ, тоо хэмжээ бүхий бүтээгдэхүүнийг чанарын батламж, дагалдах бичиг баримтын хамт тогтоосон хугацаанд тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2. Чанарь н болон тоо хэмжээний дутагдал илэрсэн гэх хангалттай үндэслэл байвал худалдан авагч тэгэш шатахууныг өөрийн саванд буулгаж авахаас өмнө гомдол гаргах эрхтэй бөгөөд



худалдагч нь нийлүүлсэн бүтээгдэхүүнийг чанарын шаардлага хангасан ижил төрөл, чанар, стандартын бараагаар ажлын 3 хоногийн дотор солих, дутуг нөхөн нийлүүлнэ. Хэрвээ энэ хугацаанд дутагдалтай барааг солих, дутуг нөхөх үргээ биелүүлээгүй бол худалдан авагч болон төлбөр төлөгч талд учирсан хохирлыг барагдуулна.

- 3.3. Худалдан авагчтай харилцан тохиролцсоны дагуу гэрээнд заасан нэр төрөл, хэмжээ бүхий шатахууныг тогтоосон хугацаанд нийлүүлэх үүрэгтэй.
- 3.4. Гэрээ байгуулснаар өөрт ил болсон худалдан авагч талын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар задруулахгүй байх, зүй бусаар ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.5. Гэрээгээр тогтоосон хугацаанд үнийг төлөхийг, гэрээний дагуу төлүүлэхээр төлбөр төлөгч талаас шаардах эрхтэй.
- 3.6. Худалдан авагч нь гэрээгээр тогтоосон хугацаанд шатахууны үнийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд худалдагч шатахууны дараагийн нийлүүлэлтийг зогсоох эрхтэй. Ийнхүү нийлүүлэлтийг зогсоосноос шалтгаалан худалдан авагчид учирсан хохирлыг худалдагч тал хариуцахгүй.
- 3.7. Худалдагч шатахууны нийлүүлэлтийг зогсоогоогүй нь худалдан авагч хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 3.8. Худалдан авагч тал нь газрын тосны бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд хүлээн аваагүй ба хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах нь үнийг төлөхөөс татгалзах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд худалдагч тал гэрээг цуцлах буюу цуцлахгүйгээр учирсан хохирлыг төлүүлэх, гэрээний үүргийг шаардах эрхтэй.

#### **Худалдан авагч талын эрх, үүрэг**

- 3.9. Гэрээгээр тохиролцсон хэмжээ, чанар бүхий шатахууныг тогтоосон хугацаанд нийлүүлэхийг худалдагчаас шаардах эрхтэй.
- 3.10. Шатахууныг нийлүүлмэгц захиалгат шатахууныг тогтоосон хугацааны дотор “Эзэлхүүний арга”-аар шалгаж хүлээн авах үүрэгтэй.
- 3.11. Шатахуун нийлүүлэлтэй холбоотой баримт мэдээлэл, санхүүгийн тооцоог гаргуулан авах эрхтэй.
- 3.12. Худалдан авагчийн барааны захиалга, худалдан авалтын ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих эрхтэй.
- 3.13. Санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн Худалдан авагчаас Худалдагчид төлөх мөнгөн төлбөрийн үүргийг энэ гэрээнд заасан хугацаанд төлөх, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр алдангийг төлөх үүрэгтэй.
- 3.14. Худалдан авагч талын худалдан авсан шатахууны төлбөрийг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

#### **ДӨРӨВ. ШАТАХУУНЫ ХЭМЖЭЭ, ҮНЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ**

- 4.1. Худалдагчаас худалдан авагчид нийлүүлсэн шатахууны нарийвчилсан хэмжээг Худалдагч, Худалдан авагч талуудын гарын үсэг зурсан орлого, зарлагын баримтад бичсэн хэмжээг үндэслэн тооцно.
- 4.2. Худалдан авагч тал тухайн сарын захиалгын хэмжээг захиалгыг биелүүлэх өдрөөс ажлын 3 /гурав/ хоногийн өмнө албан бичиг болон цахим шуудангаар худалдагч талд хүргүүлнэ.
- 4.3. Худалдан авагч талд нийлүүлэх шатахууны үнийг тооцохдоо худалдагч талын урьдчилан ирүүлсэн нэгжийн үнэ тооцох томъёоны дагуу сар бүр Бөөнөөр борлуулах үнийн саналыг хүргүүлнэ. Энэхүү үнэ тооцох томъёо нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.4. Худалдан авагч талын гэрээгээр хүлээсэн шатахууны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах зорилгоор худалдан авалтын явцын мэдээлэл болох нэхэмжлэлийг худалдан авалт хийгдсэний дараа, тооцоо нийлсэн актыг баталгаажуулсны дараа тус тус хүргүүлэх үүргийг Худалдагч тал хүлээнэ.
- 4.5. Худалдагч, Худалдан авагч талууд нь 14 хоног тутамд худалдан авсан шатахууны тооцоог нийлж актаар баталгаажуулна. Тэрхүү тооцоо нийлсэн акт нь гэрээний салшгүй хэсэг байна. Тооцоо нийлсэн актанд энэхүү гэрээний огноо, дугаар дурьдагдсан байна.

- ИЛ БОГСОН** **МАШНҮҮН**
- 4.6. Худалдан авагч тал нь 4.2-т заасан захиалгын үнийн дүнгийн 30 /түч/ хувийг захиалахаа биелэх өдрөөс ажлын 5 /тав/ хоногийн өмнө худалдагч талын 4.9-т заасан дансанд байршуулна.
  - 4.7. Худалдан авагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлууд нь Худалдагчаас худалдан авсан шатахууны төлбөрийг төлөхгүй байх ундэслэл болохгүй.
  - 4.8. Худалдан авагч нь авсан шатахууны үнийг тооцоо нийлсэн актыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор 4.9-д заасан дансаар төлнө.
  - 4.9. Шатахууны үнийг худалдагч талын дараах дансанд төлнө.

Худалдагчийн банк	Валют	Дансны дугаар
Худалдаа хөгжлийн банк	Төгрөг	406073358
ХААН Банк	Төгрөг	5038026973
Голомт банк	Төгрөг	2105005768

#### ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 5.1. Худалдан авагч шатахууны төлбөрийг гэрээний 4.8-д заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувиар тооцон худалдагчид алданги төлнө.
- 5.2. Худалдагч тал нь гэрээгээр тохирсон хугацаанд шатахууныг нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувиар тооцон Худалдан авагчид алданги төлнө.

#### ЗУРГАА. ФОРС МАЖОР БОЛОН HARDSHIP

- 6.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй /форс мажор/ нөхцөл байдалд байгалийн аюулт үзэгдэл, гэнэт үерт автах, гол түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал, хорио цээр болон бусад байгалийн хүчин зүйлс, цэрэг, дайны үйл ажиллагаа, HARSHIP нөхцөл байдалд төрийн эрх барих байгууллагын шийдвэр, экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сүл зогсолт энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно. Хэрэв дээрх нөхцөл байдлууд 20 /хорь/ хоногоос илүү хугацаагаар үргэлжилбэл Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаар гэрчлүүлсний үндсэн дээр энэхүү гэрээний аль ч тал энэхүү гэрээний дагуух нийлүүлэлтийг нөгөө талдаа мэдэгдэн цуцлах эрхтэй.
- 6.2 Форс мажор нөхцөл байдалд аль ч тал гомдлын шаардлага гаргах ба аливаа алдагдлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нөгөө талдаа тийм нөхцөл байдал үссэн болон арилсан тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.
- 6.3 HARSHIP нөхцөл байдалд аль нэг тал үүргээ бүрэн биелүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байгаа тохиолдолд талууд тохиролцож гэрээний нөхцлийг өөрчлөх, гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ

#### ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад гараг аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 7.2 Талууд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### НАЙМ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 8.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж, цуцалж болно. Гэрээ цуцлах, гэрээнээс татгалзах, дуусгавар болгохтой холбогдсон харилцааг Иргэний хуульд заасан зохицуулалтаар нарийвчлан зохицуулна.



- 9.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр хүртэл байгуулав.
- 9.2. Гэрээний хугацаа нь талуудаас үүрэг гүйцэтгэх, шатахууны үнийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой харилцаанд ямар нэгэн хугацааг тодорхойлохгүй.
- 9.3. Гэрээний хугацаа дуусахад аль нэг тал нь гэрээг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

#### АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, талууд гарын үсэг зуран баталгаажуулснаар /тамга дарж/ хүчин төгөлдөр болно. Гэрээний хувиуд нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй ба худалдагч тал 1 хувь, төлбөр төлөгч тал 2 хувийг хадгална.
- 10.2. Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 10.3 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл болон Гэрээтэй холбогдон нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж 3-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа Гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар эсвэл биечлэн хургүүлснийг хүчинтэйд тооцно.
- 10.4 Энэхүү Гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан Гэрээнд тусгагдсан болон Гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед Гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөрсдөө хариуцна.

Талууд:

“Шунхлай Трейдинг” ХХК-ийг  
төлөөлж:  
Борлуулалт, маркетинг хариуцсан  
захирал Ч.Галмөнх

Хуулийн зөвлөх  
Г.Шижирбаатар

Бөөний борлуулалтын менежер  
Д.Энхмандал 91915336/

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийг  
төлөөлж:  
Төсөл хөгжлийн газрын дарга  
Э.Эрдэнэбат